БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2020/187/СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: П.Амаржаргал
Утас: 99890393 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com
Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2020 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Агуулга

Аудитын гэрчилгээ ........ 3
Аудитын тайлан........ 5
**2.1.** Оршил ........ 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5
**2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**........ 5
**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**........ 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал........ 6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 7
2.13. Шилэн дансны мэдээлэл ........ 7
**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**........ 8
**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**........ 8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан........ 9
**1.1** Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ........ 9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан........ 9
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 10
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 11
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 12



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.02.27 № 1/226

танай ____________ -ны № ____________ -т

БАЯНХОНГОР СУМЫН 16 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ С.УЧРАЛСАЙХАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020184



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.1.** Оршил

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч С.Учралсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-наас 2020 оны 01 дүгээр сарын 30–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 6 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд хувийн онцлог, хүсэл сонирхлоороо өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн чадвар, дадал, төлөвшлийг эзэмшихэд чиглэгдсэн арга барилыг эзэмшсэн багш ажилтантай "Сайн туршлага"-ыг түгээгч байгууллага болно" оршино.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хамран сургах тойргийн 2-5 насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үндсэн чиг үүрэгтэй. Хамран сургах тойргийн хүүхдүүдийг үндсэн болон хувилбарт сургалтад хамруулан сургуулийн өмнөх боловсрол олгох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 16-р цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 113406,3 мянган төгрөгөөр тооцон 2268,1 мянган төгрөгөөр тооцож үзсэнтэй холбоотой юм.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 16 дугаар цэцэрлэг нь 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Тус байгууллагын жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар 81580,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж орлогод авсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 00.00 | 76,728.94 | 76.73 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 00.00 | 76,728.94 | 76.73 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 00.00 | 79,932.12 | 79.93 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 00.00 | 81,580.90 | 81.58 |
| | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -1,648.80 | -1.65 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 00.00 | 156,661.06 | 156.66 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 00.00 | 156,661.06 | 156.66 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 00.00 | 156,661.06 | 156.66 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 00.00 | 156,661.06 | 156.66 |

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант онд 156661,0 мянган төгрөг байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор сумын 16-р цэцэрлэг нь төвлөрүүлэх орлого байхгүй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71801 хөтөлбөрт зориулан 80802 /ажил олгогчоос оруулах тэтгэмж/, 81807 /цэцэрлэгийн хүүхдийн хоол/, 81831 /ээлжийн бүлэгт хамруулах/, 81834 /боловсролын стандарт сургалтыг хангах/, 81835 / сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах/-д зориулалттай 231599,8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 231599,8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан шалгахад:

Тайлант онд улсын төсвөөс авах 231599,8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авчээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 231599,8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь улсын төсвөөс 231599,8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус цэцэрлэгийн барилгыг улсын комисс хүлээн авсан хэдий ч аймгийн ИТХ-аар эзэмшигч тогтоож хөрөнгийг орлогод авах шийдвэр гараагүй байгаа тул 2019 оны санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй байна. Иймд дараагийн аудитаар эрх бүхий байгууллагын шийдвэр гарч хөрөнгийг байгууллагын бүртгэлд тусгасан эсэх талаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 16-р цэцэрлэг нь 2019 оны 10 дугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

7 мэдээллийг хугацаанд нь, 36 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Энэ нь аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны шилэн дансны хуулийн хэрэгжилтийн шалгалттай холбоотойгоор дахин засварлан оруулсантай холбоотой байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 2 | 7 | 2 |
| 2 | Хагас жил | 0 | 0 | 0 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 1 | 1 | 0 | |
| 4 | Сар бүр | 3 | 9 | 1 | 8 | |
| 5 | Тухай бүр | 8 | 24 | 3 | 21 | |
| | Нийт | 27 | 45 | 7 | 36 | 2 |

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Баянхонгор сумын 16-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**1.1** Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 00.00 | 76,728,935.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 00.00 | 76,728,935.00 |
| 351 | **Түүхий эд материал** | 00.00 | 73,857,072.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 00.00 | 73,787,072.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 70,000.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 00.00 | 2,871,863.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 25,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 00.00 | 168,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 597,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 42,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 2,039,763.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 00.00 | 79,932,124.99 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 00.00 | 79,932,124.99 |
| 392 | **Биет хөрөнгө** | 00.00 | 79,066,791.66 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 00.00 | 25,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -138,888.89 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 00.00 | 27,666,780.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -657,221.37 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 00.00 | 28,034,191.66 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -838,069.74 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 865,333.33 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 880,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -14,666.67 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 00.00 | 156,661,059.99 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 00.00 | 156,661,059.99 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 00.00 | 156,661,059.99 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 00.00 | 156,661,059.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 156,661,059.99 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 00.00 | 156,661,059.99 |

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **00.00** | **270,067,371.66** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **38,467,571.66** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 38,467,571.66 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 38,467,571.66 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 38,467,571.66 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 231,599,800.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **00.00** | **113,406,311.67** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **00.00** | **113,406,311.67** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 00.00 | 113,188,392.67 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 00.00 | 76,368,526.00 |
| 210101 | Үндсэн цалин | 00.00 | 48,791,326.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 19,251,900.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 8,325,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 00.00 | 8,184,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 4,897,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 820,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 752,050.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 73,750.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 1,640,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 8,630,289.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 2,141,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 2,923,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 2,470,189.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 45,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 1,050,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 8,425,392.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 28,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 8,396,992.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 9,493,939.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 9,493,939.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 432,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 432,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 00.00 | 1,652,746.67 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 3,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 00.00 | 1,648,846.67 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 00.00 | 217,919.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 210,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 210,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,119.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,119.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **00.00** | **156,661,059.99** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **00.00** | **156,661,059.99** |

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **00.00** | **231,599,800.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **00.00** | **231,599,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 231,599,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **00.00** | **231,599,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **00.00** | **231,599,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **00.00** | **231,381,881.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 00.00 | 76,368,526.00 |
| 210101 | Үндсэн цалин | 00.00 | 48,791,326.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 19,251,900.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 00.00 | 8,325,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 00.00 | 8,184,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 4,897,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 737,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 678,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 230,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 1,640,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 00.00 | 22,414,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 00.00 | 525,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 3,520,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 2,587,461.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 28,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 45,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 15,708,339.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 38,535,155.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 98,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 10,436,755.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 28,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 79,079,300.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 45,756,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 33,323,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 1,312,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 1,312,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 00.00 | 5,486,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 5,486,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **00.00** | **217,919.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 210,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 210,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 7,119.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 7,119.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 156,661,059.99 | 156,661,059.99 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **156,661,059.99** | 156,661,059.99 |

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 231,599,800.00 | 231,599,800.00 | 0.00 | 100.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 231,599,800.00 | 231,599,800.00 | 0.00 | 100.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 231,389,000.00 | 231,389,000.00 | 0.00 | 100.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 76,375,600.00 | 76,375,600.00 | 0.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 48,798,400.00 | 48,798,400.00 | 0.00 | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 19,251,900.00 | 19,251,900.00 | 0.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 8,325,300.00 | 8,325,300.00 | 0.00 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 8,184,600.00 | 8,184,600.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,897,500.00 | 4,897,500.00 | 0.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 737,500.00 | 737,500.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 678,300.00 | 678,300.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 230,800.00 | 230,800.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,640,500.00 | 1,640,500.00 | 0.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,414,700.00 | 22,414,700.00 | 0.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 190,100.00 | 525,900.00 | - 335,800.00 | 276.64 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,520,000.00 | 3,520,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,461,400.00 | 2,587,461.00 | 873,939.00 | 74.75 |
| 210404 | Ном, хэвлэл | 105,400.00 | 28,000.00 | 77,400.00 | 26.57 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 45,000.00 | 45,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,092,800.00 | 15,708,339.00 | - 615,539.00 | 104.08 |
| **2105** | **Нормативт зардал** | 38,535,200.00 | 38,535,200.00 | 0.00 | 100.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,400.00 | 98,400.00 | 0.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,436,800.00 | 10,436,800.00 | 0.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 28,000,000.00 | 28,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 79,079,300.00 | 79,079,300.00 | 0.00 | 100.00 |
| 210602 | Тавилга | 45,756,000.00 | 45,756,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,323,300.00 | 33,323,300.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,312,900.00 | 1,312,900.00 | 0.00 | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,312,900.00 | 1,312,900.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5486700.00 | 5486700.00 | 0.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,486,700.00 | 5,486,700.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 210800.00 | 210800.00 | 0.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 210,800.00 | 210,800.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 210,800.00 | 210,800.00 | 0.00 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 39.00 | 39.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26.00 | 26.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 | 0.00 | 100.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: П.АМАРЖАРГАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

6417143544
БЮА0067 9007423



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ